



2021 оны үйл ажиллагааны тайлан

www.dsedn.mn

<https://tsakhilgaan.mn>



Бүтэц, орон тоо

2021 онд бодлого зохицуулалтын 5 хэлтэс, мэдээлэл технологи, шуурхай удирдлага, засвар туршилт, хэмжүүр тоолуур, тээвэр үйлчилгээний чиглэлээр ажиллах 5 алба, тоног төхөөрөмжийн ашиглалт борлуулалтын ажлыг эрхлэн гүйцэтгэх 4 салбар, 2 төвтэйгөөр 442 орон тоотой ажиллаж байна.





Худалдан авсан ЦЭХ

2021 оны жилийн эцэст нэг худалдан авагчаас 496,4 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч худалдан авахаар төлөвлөснөөс 603,9 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч худалдан авч төлөвлөгөөнөөс 21,7%-иар буюу 107,5 сая.кВт.цагаар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 24,6%-иар буюу 119,3 сая.кВт.цагаар өссөн байна.



Үзүүлэлт	Хэмжих нэгж	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Өссөн дүн
2020 оны гүйцэтгэл	сая кВт цаг	35.4	32.3	30.7	37.3	39.6	42.4	40.7	40.8	44.1	50.4	46.1	44.8	484.6
2021 оны захиалга	сая кВт цаг	41.0	37.0	38.0	42.5	44.8	40.3	39.8	40.5	41.8	46.5	42.6	41.6	496.4
2021 оны гүйцэтгэл	сая кВт цаг	47.0	40.9	50.4	50.6	50.3	51.6	47.5	51.0	52.3	57.3	53.3	51.6	603.9
өмнөх оны гүйцэтгэлээс бууралт	биет сая кВт цаг	11.6	8.7	19.7	13.3	10.7	9.2	6.8	10.2	8.2	7.0	7.3	6.8	119.3
	хувь хувь	32.8%	26.9%	64.2%	35.6%	26.9%	21.6%	16.7%	24.9%	18.7%	13.8%	15.8%	15.2%	24.6%
тухайн оны анхны захиалгаас	биет сая кВт цаг	6.0	3.9	12.4	8.1	5.5	11.3	7.7	10.5	10.5	10.9	10.7	10.0	107.5
	хувь хувь	14.6%	10.7%	32.5%	19.0%	12.3%	28.2%	19.3%	25.9%	25.2%	23.4%	25.1%	23.9%	21.7%



Борлуулсан ЦЭХ

Тайлант хугацаанд гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөөгөөр 533,6 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч борлуулалхаас 564,5 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч борлуулж өмнөх оны мөн үеэс 124,0 сая кВт.цагаар өсөж төлөвлөгөөний биелэлт 105,8% боллоо.





Түгээлтийн алдагдал

Тайлант хугацаанд цахилгаан эрчим хүчний нийт алдагдал 6.51% буюу 39.3 сая.кВт.цаг болсон нь төлөвлөгөөт алдагдлыг /11.50%/ 5,0 нэгжээр буюу 17.7 сая.кВт.цагаар буурсан, өмнөх оны гүйцэтгэлээс 0.06 нэгжээр буюу 4.7 сая.кВт.цагаар буурсан байна.





ЦЭХ-ний орлого

Гүйцэтгэлд ноогдох орлогын төлөвлөгөөний дагуу 91,6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 101,6 тэрбум төгрөгийн орлого цуглуулж гүйцэтгэлд ноогдох орлогын төлөвлөгөө 112,9%-ийн гүйцэтгэлтэй байна.






Засгийн газрын хөнгөлөлт

Засгийн газрын 2020 оны 211 тоот тогтоол, Эрчим хүчний сайдын 267, 269 дүгээр тушаалаар батлагдсан түр журмын дагуу хөнгөлөлтөнд нийт хэрэглэгчийн 96 орчим хувь нь хамрагдаж байна.

2020 оны 12 дугаар сараас 2021 оны өссөн дүнгээр борлуулалтын орлогын 23% нь засгийн газрын хөнгөлөлтөнд хамрагдсан.

Борлуулалтын орлогын бүтэц



■ МУЗГ-ын хөнгөлөлт


■ Хэрэглэгч өөрөө хариуцах



Засгийн газрын хөнгөлөлт

2020 оны 12 дугаар сараас 2021 оныг дуустал давхардсан тоогоор 546 мянган ахуйн хэрэглэгчид, 32 мянган ААНБ-ийн хэрэглэгчид, нийт 578 мянган хэрэглэгчдэд 148,1 сая.кВт.цагийн 26,4 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг эдлүүлж 22,2 тэрбум төгрөгийн санхүүжилт аваад байна. Нийт санхүүжилт 84,0%-ийн гүйцэтгэлтэй гарсан.

Монгол улсын засгийн газрын санхүүжилт





ЭХХэмнэлтийн төлөвлөгөөний гүйцэтгэл



2021 онд Эрчим хүч хэмнэх, алдагдал бууруулах чиглэлээр 24 ажил төлөвлөсөн үүнээс 35/6 кВ Зүүнбүрэн дэд станцын халаагуурт удирдлагын хайрцаг тавих 1 ажил 2022 оны урсгал засварын ажилтай хамт хийгдэхээр шилжсэнтэй холбогдон ажлын гүйцэтгэл 98 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн.

Тус Эрчим хүч хэмнэх, алдагдал бууруулах чиглэлээр хийх ажилд 842,8 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэл 898,3 сая төгрөгний зардалд гүйцэтгэсэн.



Дотоод хэрэгцээний зарцуулалт

Дотоод хэрэгцээний зардал / сая төг /



2021 онд компанийн дотоод хэрэгцээний зардал өмнөх оноос 4,0 сая төгрөг буюу 1,1 хувиар өссөн. Дотоод хэрэгцээний зардалын өсөлтөнд дараах шалтгаанууд нөлөөлсөн.

- 2021 онд барилгын засварын ажилууд ихээхэн хийгдсэнтэй холбогдон цахилгааны зардал 3,3 сая төгрөгөөр өссөн. Тухайлбал 35/6 кВ Хонгор дэд станцын шинэчлэлийн ажил, төв конторын коридор, ажилчидын цайны газарын засвар зэрэгээс шалтгаалан цахилгааны хэрэглээ өссөн.
- Дулааны зардал өсөлттэй гарсан шалтгаан нь Сүхбаатар салбарын 2020 оны сүүлийн 2 сарын дулааны зардал 2021 онд шилжиж орсонтой холбогдон өссөн дүнтэй гарсан байна. Харин усны хэрэглээ 8,0 сая төгрөгөөр буурсан.



Эрчим хүчний хэмнэлт

Техникийн алдагдалыг бууруулах зорилгоор 2021 оны Эрчим хүч хэмнэлтийн төлөвлөгөөнд тусгаж 250 кВа чадалтай Аморф зүрхэвчтэй трансформатор 1 ширхэгийг худалдан авч Дархан суманд байрлах АТП-144 дэд станцад суурилуулж тавьсан.



Үзүүлэлт	Өмнөх ТМ тр-р	Дараах Аморф тр-р	Зөрүү
Чадал /кВа/	250	250	0
Рхх Вт	820	150	-670
Сар /кВт цаг/	590	108	-482
Сар /төгрөг/	106755	19528	-87227
Жил /төгрөг/	1281059	234340	-1046719

Уламжлалт хийцийн 250 кВа чадалтай ТМ тр-рыг аморф зүрхэвчтэй тр-раар сольсноор тр-ын хоосон явалтын алдагдал сард 482 кВт цаг жилд 5784 кВт цаг эрчим хүч хэмнэх тооцоо гарч байна. Хэмнэсэн эрчим хүчийг борлуулалтын төгрөгөөр тооцвол жилд 1,0 сая төгрөг байна.



Эрчим хүчний хэмнэлт



Д/д	Чадал кВа	Уламжлалт хийцийн ТМ маркийн тр-р Рхх Вт		Шинэ хийцийн ТМГ маркийн тр-р Рхх Вт		Тоо ширхэг	Зөрүү кВт	Сар кВт.цаг	Жилд кВт.цаг	Сар Төгрөг	Жилд Төгрөг
		нэгж тр-р	нийт тр-р	нэгж тр-р	нийт тр-р						
1	ТМГ-160/10У1	540	540	410	410	1	0.13	94	1123	15386	184632
2	ТМГ-250/10У1	820	4100	530	2650	5	1.45	1044	12528	171613	2059353
3	ТМГ-250/6У1	820	3280	530	2120	4	1.16	835	10022	137290	1647482
4	ТМГ-400/10У1	1080	7560	800	5600	7	1.96	1411	16934	231973	2783677
	Дүн	3260	15480	2270	10780	17	4.7	3384	40608	556262	6675143

Техникийн алдагдалыг бууруулж эрчим хүч хэмнэх зорилгоор хоосон явалтын алдагдал, насжилт өндөртэй 10/6/0,4кВ-ын хүчний трансформаторуудыг 2016 оноос эхлэн ТЗБАХ-ын төлөвлөгөөнд шат дараатай тусгаж сольж шинэчлэх ажлуудыг хийж байна. 2021 онд 17 ш ТМГ-У1 трансформатор худалдан авч 12 тр-рыг нь суурилуулаад байна. Ингэснээр жилд 40,6 мян кВт цагаар техникийн алдагдал буурах тооцоо гарч байна.



Эрчим хүчний хэмнэлт

Модон тулгуурын хэрэглээг багасгаж байгаль экологи хамгаалах зорилгоор компани 2021 онд төмөр бетон 9 метртэй тулгуур 1844 ширхэг, 12 метртэй тулгуур 785 ширхэгийг үйлдвэрлэж ашигласан. Ингэснээр тулгуурын ашиглалтын хугацааг 3-4 дахин уртасгаж 7887 ургаа мод тайрагдаж ашиглагдахаас сэргийлсэн.





Эрчим хүчний хэмнэлт

Дэд станцуудын барилгын дулаан алдалтыг бууруулж эрчим хүчний зарцуулалтыг бууруулах зорилгоор 2021 онд 35 кВ-ын 2 дэд станцыг шинэчлэлийн ажилтай хамтатган гадна ханыг дулаалж пасад хийж, 6/04 кВ-ын 7 дэд станцын модон хаалгыг төмөр битүүмжлэл сайтай хаалгаар сольж, 15 дэд станцын дээвэр, хаяавчийг засварласан.




2021 онд Дулаан алдалт бууруулахаар хийсэн барилга засварын ажил /
тоо /





Алдагдал бууруулж хэмнэсэн эрчим хүч





Бууруулсан хүлэмжийн хий

2021 онд ЦЭХ-ний алдагдал бууруулж хэмнэсэн эрчим хүчийг хүлэмжийн хийд шилжүүлж тооцвол 303,0 тн жишмэл түлш, 615,6 тн бодит түлш хэмнэж 875,2 тн хүлэмжийн хий агаар мандалд цацагдахаас сэргийлсэн байна.

